

## НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД

ХӨДӨӨГИЙН ХҮН АМД ЭРҮҮЛ МЭНДИЙН АНХАН ШАТНЫ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭГЧ  
БАЙГУУЛЛАГУУДЫГ ӨӨРЧЛӨН БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛД

*Б.Orgil  
“ACH” Анагаах ухааны дээд сургууль*

### CHANGING AND IMPROVING PRIMARY HEALTH CARE' ORGANIZATIONS IN RURAL AREAS

*B.Orgil  
“ACH” Medical Institute*

**Introduction:** The WHO has been recommended to the member countries to develop a national health system based on PHC. Also the WONCA has given emphasis on improvement of rural health. There have been limited research studies done in Mongolia on rural health needs and improvement of PHC' organizations for rural areas.

**Goal:** To study on thoughts of rural medical personnel and rural citizens about activity of PHC' organization and its change in the nearest future.

**Objective:** 1) To introduce with current situation of Soum and Inter-Soum hospitals; 2) To study on thoughts of rural medical personnel about activity of Soum, Inter-Soum and Aimag hospitals and its further changing; 3) To study on satisfaction of rural citizens from activity of primary care organizations.

**Material and Method:** This study was covered 205 rural medical personnel (physicians - 41, feldshers - 43, nurses - 65, laboratory technicians - 11, other personnel - 45) and 210 rural citizens (local government' personnel – 86, workers of private entities – 41, herdesmen – 40, pensioners – 11, others – 32) from Arkhangai, Gobi-Altai, Dundgobi, Sukhbaatar, and Tuv aimags. Used a questionnaire method (Questionnaire for rural medical personnel was include 14 questions; for rural citizens – 13 questions). For analysis of collected materials were used biostatistic methods.

**Results:** Among the rural medical personnel – respondents 77,6% were assess positively about current soum hospital activity, which shown that a soum hospital can be implemented own main functions – to delivery PHC to rural people. Also 67,3% of respondents have thinking positively about Bag' feldsher unit and 74,6% of them have given a more attention to improve working condition for Bag' feldshers. Most of respondents – rural citizens (62,9%-80,5%) has been satisfied with soum, inter-soum hospitals care and bag' feldsher unit service. They have suggestions how to improve rural health facilities. Finally, most of respondents (as rural health personnel, as well as rural citizens) have supporting to change current soum hospital as become “Soum health centre”.

**Conclusions:**

1. Based on the results of our study (67,3-77,6% of respondents – rural medical personnel and 62,9-80,5% of rural citizens have a satisfaction with Soum and Inter-soum hospital services, and ctr.) we can conclude that rural health facilities in common have been functioned normally.
2. Most of rural health personnel (68,8% of respondents) has been supported to changing current Soum hospital and its improving as Soum health centre (by thinking 62,4% of respondents) in the nearest future.
3. Also most of rural citizens (77,7-83,3% of respondents) has thinking about changing and improving rural health facilities, especially about Soum health centre. It is very important for providing a health reform in Mongolian rural areas, successfull.

**Key words:** primary health care, rural health, Soum Health Centre

**Pp. ..., References 11.**

Үндэслэл. Орчин үед дэлхийн аль ч улс орны эрүүл мэндийн салбарын тухайд эрүүл мэндийн анхан шатны тусламж (ЭМАШТ)-д тэргүүлэх ач холбогдол өгч, улмаар ЭМАШТ дээр суурилсан эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхийг чухалчилсаар байна (4, 10). Түүнчлэн дэлхий дахинд, түүний дотор манай улсын харьялагддаг ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсэд ЭМАШТ-ийг боловсронгуй болгоход ихээхэн анхаарал хандуулсаар байна (6, 7, 11). Манай улсын тухайд, хүн амд үзүүлэх ЭМАШТ-ийн хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд анхаарч, түүнийг гардан хэрэгжүүлэгч байгууллагууд болох сумын болон өрхийн эмнэлгийг хөгжүүлэн төлөвшүүлэхэд чиглэгдсэн тодорхой арга хэмжээнүүд авч, хэрэгжүүлж ирсэнээр, багагүй ахиц, дэвшил гарсаар байна. Ялангуяа Азийн Хөгжлийн Банкны зээл, техникийн тусламжтайгаар хэрэгжүүлсэн “ЭМСХХ-1”, “ЭМСХХ-2” төслийдийн хүрээнд ихээхэн амжилт олсон (1, 3) ба одоо хэрэгжүүлж буй “ЭМСХХ-3” төслийн хүрээнд ч тодорхой үр дүн гарах бизээ.

Хөдөөгийн хүн амд үзүүлэх ЭМАШТ-ийн хүртээмж, чанарыг сайжруулах, “Хөдөөгийн эрүүл мэндийн төв”-ийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх явдал чухал нэгэн зорилт болсоор байна (8, 9). Тэр талаар Эрүүл Мэндийн Салбарын Мастер Төлөвлөгөөнд ч тодорхой

санаанууд дэвшиүүлсэн (5). Нөгөөтэйгүүр, Мянганы хөгжлийн зорилтуудын хүрээнд ч манай улс эрүүл мэндийн салбарыг, түүний дотор ЭМАШТ-ийг хөгжүүлэн, боловсронгуй болгох талд ихээхэн анхаарч байна (2).

Гэсэн ч, тус салбарын аль ч түвшинд ЭМАШТ-д тэргүүлэх ач холбогдол өгөх явдал учир дутагдалтай байна. ДЭМБ-аас зөвлөмж болгосон (4, 10) “ЭМАШТ дээр суурилсан үндэсний эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэх” асуудлыг бодитой ажил хэрэг болгох хүсэл, эрмэлзлэл үгүйлэгдсээр байна. Үүний тодорхой нэгэн жишээ бол ЭМАШТ-ийг хэрхэн хөгжүүлэх талаар үндэсний бодлогогүй байгаа явдал мөн. Хэдийгээр “ЭМСХХ-2” төслийн хүрээнд зарим сумын эмнэлэг (СЭ)-ийн материаллаг баазыг бэхжүүлэх, эмч мэргэжилтнүүдийг нь сургалтанд хамрах зэрэг арга хэмжээ авсан ч гэсэн, СЭ-ийг цаашид хэрхэн өөрчилж, хөгжүүлэх асуудал бүрхэг хэвээр байна. “ЭМСХХ-3” төслийн хүрээнд СЭ-ийг “Сумын эрүүл мэндийн төв” болгож өөрчлөх зорилт тусгагдсан боловч, уг ажлын явц удаашралтай, зарим талаар эсэргүүцэлтэй тулгарсаар байх бололтой.

Аливаа өөрчлөлтийн нэчлэлийг гажилхэрэгчээр, үр дүнтэй явуулахын тулд холбогдох объект болон субъектийн байдлыг сайтар судлан тогтоо шаардлагатай байдаг. Ялангуяа объектыг хөдөлгөж буй субъектийн санал

бодол, хүсэл эрмэлзлэл ямар байх нь чухал хүчин зүйл болдог учиртай.

**Зорилго:** Бид дээрх үндэслэлд тулгуурлан, “ЭМСХХ-3” төсөлд хамрагдсан Архангай, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар, Төв аймгийн зарим сумдаар явж, эмнэлгийнх нь байдалтай танилцахын ялдамд, цаашид өөрчлөлт шинэчлэлийг хэрхэн хийх асуудлаар санал солилцож, эрүүл мэндийн ажилтнууд болон иргэдийн санаа бодлыг судлаж, түүнийхээ үндсэн дээр зарим санал дэвшүүлэхийг зорилго болгосон юм.

**Зорилт:** Зорилгодоо хүрэхийн тулд судалгааны асуумж боловсруулах, асуумжийн хуудсаа хүмүүст тарааж, бөглүүлэн авах, тэдгээрт задлан шинжилгээ хийж, судалгааны үр дүнгээ тодорхойлох, цаашид яах талаар санал, зөвлөмж дэвшүүлэх зэрэг зорилтуудыг өмнөө тавьсан болно.

**Материал, арга зүй:** Бид дээр дурдсан 5 аймгийн 15 сумын болон сум дундын эмнэлэгтэй танилцахын ялдамд “Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн байдлын талаар эрүүл мэндийн ажилтнуудаас авах санал асуулгын асуумж”, “Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн байдлын талаар иргэдээс авах санал асуулгын асуумж” гэсэн 2 янзын хуудас бөглүүлэн авч, товч дүн шинжилгээ хийсэн. Уг асуумжийн судалгаанд хөдөөгийн эрүүл мэндийн ажилтан 205, хөдөөгийн иргэд 210 хүн тус тус хамрагдсан. Энэхүү судалгааг асуумжийн санамсаргүй түүврийн аргаар явуулсан. Тухайлбал, эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад 14 асуулт бүхий, иргэдэд 13 асуулт бүхий асуумжийн хуудас тус тус тарааж, хувийн бодол санаагаа чөлөөтэй илэрхийлэхүйц нөхцөл байдалд хариултыг нь бөглүүлж авсан. Асуумжийн хуудсаар цуглуулсан материалд статистикийн нийтлэг аргуудаар задлан шинжилгээ хийсэн.

## Үр дүн

A. Хөдөөгийн эмнэлгийн ажилтнуудын дунд асуумжийн аргаар хийсэн тандалтын дүн Хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагын 205 ажилтнаас авсан асуумжийн судалгааны материалд задлан шинжилгээ хийж үзэхэд,

дараахь байдалтай байв. Эмнэлгийн ажилтнуудыг дотор нь ангилж үзвэл: их эмч - 41, бага эмч - 43, сувилагч - 65, лаборант - 11, бусад ажилтан - 45. Тэднээс уг асуумжийн зарим асуултад хариулт өгсөн байдлыг авч үзвэл:

1.”Та өнөөгийн сумын эмнэлгийн тусlamж үйлчилгээг хэрхэн үнэлдэг вэ?” гэсэн асуултанд: “Сайн” гэж хариулсан - 82 (40,0%), “Дунд” гэсэн - 77 (37,6%), “Тааруу” гэсэн - 28 (13,7%), “Хэлж мэдэхгүй” - 18 (8,7%);

2.”Цаашид сумын эмнэлгийг явавал зохильтой вэ?” гэсэн асуултанд: 1) Сумын эмнэлгийн хүчин чадлыг өөрчлөх: а) ихэсгэх - 50 (24,4%), б) багасгах - 3 (1,5%), в) илүү зохистой бүтэцтэй болгох (“Сумын эрүүл мэндийн төв” болгох) - 88 (42,9%), 2) Оношлогоо-эмчилгээний багаж төхөөрөмжөөр нэмж хангах - 47 (22,9%), 3) Одоогийн байдлаар нь үлдээх - 3 (1,5%), 4) Хэлж мэдэхгүй - 14 (6,8%);

3. ”Та багийн бага эмчийн тусlamж үйлчилгээг хэрхэн үнэлдэг вэ?” гэсэн асуултанд: 1) сайн – 48 (23,4%), 2) дунд – 90 (43,9%), 3) тааруу – 50 (24,4%), 4) хэлж мэдэхгүй – 17 (8,3%);

4. “Ер нь цаашид багийн бага эмчийн салбарыг явавал зохильтой вэ?” гэсэн асуултанд: 1) Багийн бага эмчийг ажлын тусгайлсан байртай болгох – 153 (74,6%), 2) Сумын төвөөс явж, багийн хүн амд үйлчлүүлдэг болгох – 39 (19,0%), 3) Татан буулгах – 3 (1,5%), 4) хэлж мэдэхгүй – 10 (4,9%);

5. “Та өнөөгийн сум дундын эмнэлгийн тусlamж үйлчилгээг хэрхэн үнэлдэг вэ?” гэсэн асуултанд: 1) сайн – 62 (30,2%), 2) дунд – 79 (38,5%), 3) тааруу – 25 (12,2%), 4) хэлж мэдэхгүй – 39 (19,1%);

6. “Цаашид сум дундын эмнэлгийг явавал зохильтой вэ?” гэсэн асуултанд: 1) Сум дундын эмнэлгийн одоогийн хүчин чадлыг өөрчлөх: а) ихэсгэх – 68 (33,2%), б) багасгах – 2 (0,9%), в) илүү зохистой бүтэцтэй болгох (“Сумын эрүүл мэндийн төв” болгох) – 112 (54,6%), 2) одоогийн байдлаар нь үлдээх – 3 (1,5%), 3) хэлж мэдэхгүй – 20 (9,8%);

Түүнчлэн аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээ, төрөлжсөн нарийн мэргэжлийн

тусламжийн одоогийн байдал, цаашид хэрхэн өөрчилвэл зохистой талаархи асуултуудад хариулт авч, дүн шинжилгээ хийсэн болно.

7. “Таны бодлоор дараах чиглэлийн тусламж үйлчилгээний алийг нь чухалчилан сайжруулах нь илүү зохистой вэ?” гэсэн асуултанд (давхардсан тоогоор): 1) Амбулаторийн үйлчилгээг – 72 (35,1%), 2) Хэвтүүлэн эмчлэхийг – 20 (9,8%), 3) Гэрээр үзүүлэх үйлчилгээг – 23 (11,2%), 4) Түргэн тусламжийн үйлчилгээг – 23 (11,2%), 5) Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээг – 136 (66,3%), 6) Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг – 87 (42,4%), 7) Хэлж мэдэхгүй - 15 (7,3%);

8. “Цаашид хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг хэрхэн сайжруулах талаар өөрийн санал бодлыг чөлөөтэй илэрхийлнэ үү” гэсэн асуумжийн хэсэгт: судалгаанд хамрагдагдсан 205 хүний 145 (70,7%) нь бичгээр санал нэмэрлэсэн, 60 (29,3%) нь саналаа бичгээр илэрхийлээгүй болно.

#### *Б. Хөдөөгийн иргэдийн дунд асуумжийн аргаар хийсэн тандалтын дүн*

Хөдөөгийн тодорхой тооны иргэнээс асуумжийн хуудсаар авсан материалд задлан шинжилгээ хийж үзэхэд, дараахь байдалтай байна. Асуумжийн судалгаанд санамсаргүй тохиолдоор хамрагдсан төслийн 5 аймгийн зарим сумдыниргэн 210 хүнийгнасын байдлаар нь авч үзвэл: а) 16 хүртэл настай – 4, б) 16-49 насны – 159, в) 50-60 хүртэлх насны – 39, г) 60 ба түүнээс дээш насны – 8. Хүйсний ялгаагаар авч үзвэл: эрэгтэй - 82, эмэгтэй - 128. Тэдний ажил эрхлэлтийн байдлыг сонирхвол: 1) төр засгийн байгууллагад ажилладаг – 86 (41,0%), 2) хувийн хэвшлийн байгууллагад ажилладаг – 19 (9,0%), 3) хувиараа хөдөлмөр эрхэлдэг – 22 (10,5%), 4) мал малладаг – 40 (19,0%), 5) гэрийн ажилтай – 7 (3,3%), 6) тэтгэвэрт байдаг – 11 (5,2%), 7) суралцдаг – 6 (2,9%), 8) группт байдаг – 7 (3,3%), 9) ямар ч ажил эрхэлдэггүй – 12 (5,7%). Уг асуумжийн дараахь асуултуудад иргэдээс ямар хариулт өгсөн байдлыг авч үзвэл:

1.”Та өнөөгийн сумын эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрхэн үнэлдэг вэ?” гэсэн асуултанд хариулт өгсөн байдал: 1) сайн – 85 (40,5%), 2)

дунд – 84 (40,0%), 3) тааруу – 29 (13,8%), 4) хэлж мэдэхгүй – 12 (5,7%).

2. “Ер нь цаашид сумын эмнэлгийг явал зохилтой вэ?” гэсэн асуултанд: 1) Сумын эмнэлгийн одоогийн хүчин чадлыг өөрчлөх: а) ихэсгэх – 50 (23,8%), б) багасгах – 7 (3,3%), в) илүү зохистой бүтэцтэй болгох (“Сумын эрүүл мэндийн төв” болгох) – 118 (56,2%), 2) одоогийн байдлаар нь үлдээх – 14 (6,7%), 3) хэлж мэдэхгүй - 21 (10,0%).

3. “Та багийн бага эмчийн тусламж үйлчилгээг хэрхэн үнэлдэг вэ?” гэсэн асуултанд: 1) сайн – 60 (28,6%), 2) дунд – 72 (34,3%), 3) тааруу – 51 (24,3%), 4) хэлж мэдэхгүй – 27 (12,8%).

4. “Ер нь цаашид багийн бага эмчийн салбарыг явал зохилтой вэ?” гэсэн асуултанд: 1) Багийн бага эмчийг ажлын тусгайлсан байртай болгох – 126 (60,0%), 2) Сумын төвөөс явж, багийн хүн амд үйлчлүүлдэг болгох – 51 (24,3%), 3) Татан буулгах – 8 (3,8%), 4) хэлж мэдэхгүй - 25 (11,9%).

5. “Та өнөөгийн сум дундын эмнэлгийн тусламж үйлчилгээг хэрхэн үнэлдэг вэ?” гэсэн асуултанд: 1) сайн – 87 (41,4%), 2) дунд – 67 (31,9%), 3) тааруу – 22 (10,5%), 4) хэлж мэдэхгүй – 34 (16,2%).

6. “Ер нь цаашид сум дундын эмнэлгийг явал зохилтой вэ?” гэсэн асуултанд: 1) Сум дундын эмнэлгийн одоогийн хүчин чадлыг өөрчлөх: а) ихэсгэх – 60 (28,6%), б) багасгах – 10 (4,8%), в) илүү зохистой бүтэцтэй болгох (“Сумын эрүүл мэндийн төв” болгох) – 93 (44,3%), 2) одоогийн байдлаар нь үлдээх – 13 (6,1%), 3) хэлж мэдэхгүй – 34 (16,2%).

Түүнчлэн аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээний талаархи асуултуудад иргэдээс хариулт авч, дүн шинжилгээ хийсэн болно.

7. “Таны бодлоор дараах чиглэлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний алийг нь чухалчилан сайжруулах нь илүү зохистой вэ?” гэсэн асуултанд (давхардсан тоогоор): 1) Амбулаторийн үйлчилгээг – 52 (24,8%), 2) Хэвтүүлэн эмчлэхийг – 48 (22,9%), 3) Гэрээр хийх үйлчилгээг – 27 (12,9%), 4) Түргэн тусламжийн үйлчилгээг – 27 (12,9%), 5) Аливаа урьдчилан сэргийлэх арга хэмжээг – 102

(48,6%), 6) Эрүүл мэндийг дэмжих асуудлыг – 46 (21,9%), 7) Хэлж мэдэхгүй – 21 (10,0%).

8. “Цаашид хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг хэрхэн сайжруулах талаар өөрийн санал бодлыг чөлөөтэй илэрхийлнэ үү” гэсэн асуумжийн хэсэгт: судалгаанд хамрагдагдсан 210 хүний 126 (60,0%) нь бичгээр санал нэмэрлэсэн, 84 (40,0%) нь саналаа бичгээр илэрхийлээгүй болно.

**Хэлцэмж:** Эндээс товч дүн шинжилгээ хийж үзэхэд: бидний асуумжийн судалгаанд хамрагдсан хөдөөгийн эрүүл мэндийн ажилтнуудын 77,6% нь сумын эмнэлгийн өнөөгийн үйл ажиллагаанд эерэг үнэлгээ өгсөн бол, 13,7% нь “тааруу” гэсэн үнэлгээ өгч, үлдэх 8,7% нь “хэлж мэдэхгүй” гэсэн хариулт өгснөөс ургуулан бодвол, сумын эмнэлэг иргэдэд ЭМАШТ-ийг үзүүлэх үндсэн үүргээ биелүүлж байна гэж үзэж болох юм.

Суманд ажиллаж буй эмнэлгийн ажилтнуудын 67,3% нь өнөөгийн Багийн бага эмчийн салбарын үйл ажиллагаанд эерэг үнэлгээ өгөхийн зэрэгцээ дийлэнх хувь (74,6%) нь цаашид багийн бага эмчийг ажлын байртай болгоход санаа зовож байдаг нь харагдлаа. Түүний зэрэгцээ судалгаанд хамрагдсан эмнэлгийн ажилтнуудын тодорхой хувь (19,0%) нь багийн бага эмчийг сумын төвөөс хөдөө рүү явж үйлчилдэг байхыг дэмжиж байна.

Түүнчлэн сум дундын эмнэлгийн өнөөгийн байдлыг үнэлэх талд ч хөдөөгийн эмнэлгийн ажилтнууд сумын эмнэлэг, багийн бага эмчийн салбарынхтай адил төстэй бодол санаатай болох нь харагдлаа. Сум дундын эмнэлгийг цаашид яах тухайд судалгаанд хамрагдагсын 88,7% нь боловсронгуй болгож өөрчлөх саналтай байв.

Аймгийн нэгдсэн эмнэлэг (АНЭ)-ийн үйл ажиллагааг үнэлэх талд ч хөдөөгийн эрүүл мэндийн ажилтнуудын дунд эерэг санаа бодолтой хүмүүс зонхицж (88,3%) байна. АНЭ-ийг цаашид хэрхэн өөрчлөх тухайд ч хөдөөгийн эмнэлгийн ажилтнуудын санал бодол нь дээр дурдсан баг, сум, сум дундын эмнэлгийнхтэй адил төстэй хандлагатай байна. Ер нь аймагт эмнэлгийн ямар төрөлжсөн нарийн мэргэжлийн тусlamжийг

цаашид илүүтэй анхаарах шаардлагатай талаар төслийн аймаг тус бүрт бага зэргийн ялгаа байвч, өрөнхийдөө мэс заслын, эх барих-эмэгтэйчүүдийн, лабораторийн, дүрс оношлогооны, хүүхдийн, эм хангамжийн тусlamж үйлчилгээг сайжруулахад илүүтэй анхаарах эрэлт хэрэгцээ байх бололтой.

Эмнэлгийн тусlamжийн зохион байгуулалтын хэлбэр талаас нь авч үзэх юм бол: хөдөөгийн эрүүл мэндийн ажилтнуудын олонхи нь амбулаторийн, гэрийн болон түргэн тусламжийн үйлчилгээг өргөжүүлэхэд чухалчилан анхаарч, урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай хэмээн үзэж байна.

Иргэдийн дунд асуумжийн хэлбэрээр явуулсан тандалтын товч дүн шинжилгээнээс ургуулан бodoход: хөдөөгийн иргэдийн дийлэнх хувь нь сумын эмнэлгийн өнөөгийн үйл ажиллагаанд, багийн бага эмчийн үйлчилгээнд, мөн сум дундын эмнэлгийн байдалд тус тус эерэг үнэлгээ өгсөн байлаа. Гэхдээ иргэд, хөдөөгийн хүн амд ЭМАШТ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж, тодорхой өөрчлөлт хийх саналтай байдгаа илэрхийлсэн байв.

Бас эмнэлгийн тусlamжийн зохион байгуулалтын ямар хэлбэрийг түлхүү хөгжүүлэхийг хүсч байгаа талаар хөдөөгийн иргэдийн санал бодлыг судалж үзэхэд: амбулаторийн, гэрийн болон түргэн тусламжийн үйлчилгээг өргөжүүлэхэд чухалчилан анхаарч, урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай гэдэг талаар хөдөөгийн эмнэлгийнхэнтэй адил төстэй санал бодолтой байна.

#### Дүгнэлт:

- Бидний асуумжийн судалгаанд хамрагдсан хөдөөгийн эрүүл мэндийн нажилтнууд (ЭМА)-ын 77,6% нь, иргэдийн 80,5% нь сумын эмнэлгийн өнөөгийн үйл ажиллагаанд; ЭМА-уудын 67,3% нь, иргэдийн 62,9% нь багийн бага эмчийн үйлчилгээнд; ЭМА-уудын 68,7% нь, иргэдийн 73,3% нь сум дундын эмнэлгийн ажилд тус тус эерэг

үнэлгээ ёгсөн байгаагаас үзэхэд, хөдөөгийн анхан шатны эмнэлгийн байгууллагууд хүн амд ЭМАШТ үзүүлэх үндсэн үргээ зохих хэмжээгээр биелүүлж байна гэж дүгнэж болох юм.

2. Судалгаанд хамрагдсан хөдөөгийн эрүүл мэндийн ажилтнуудын 68,8% нь сумын эмнэлгийг өөрчлөн зохион байгуулах саналтай, улмаар 62,4% нь цаашид “Сумын эрүүл мэндийн төв” болгож өөрчлөх саналтай байгаагаас үзэхэд, тэд өнөөгийн сумын эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг оновчтой арга хэлбэрээр өөрчлөхийг дэмжиж байна.
3. Хөдөөгийн иргэдийн 83,3% нь сумын эмнэлгийг, 88,1% нь багийн бага эмчийн салбарыг, 77,7% нь сум дундын эмнэлгийг тус тус өөрчлөн зохион байгуулах саналтай байгаагийн дотор 67,4% нь сумын эмнэлгийг цаашид “Сумын эрүүл мэндийн төв” болгож өөрчлөх саналтай байгаагаас үзэхэд, тэд өнөөгийн сумын эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг зохистой өөрчлөхийг дэмжиж буй нь тодорхой үндэслэлтэй гэж үзэж болохоор байна.

Дээр өгүүлсэн зүйлээс үүдэн, дараахь хэдэн санааг зөвлөмж хэлбэрээр дэвшүүлж байна.  
Тухайлбал:

- 1) Ямар ч улс орны эрүүл мэндийн салбарын үндсэн суурь буюу гол тулгуур нь ЭМАШТ байх учиртайг хaa хаанаа гүнээ ухамсарлаж, ЭМАШТ-ийг тууштай хөгжүүлэхэд нухацтай анхаарууштай байна.
- 2) Хүн амд ЭМАШТ-ийг тэгш, шудрага, хүртээмжтэй бөгөөд чанартай үзүүлэх үндсэн зарчмыг ЭМЯ-наас эхлээд Сумын эмнэлэг хүртэлх бүх түвшинд тутштай баримталдаг болмоор байна.
- 3) Нүүдлийн соёл иргэншлийг хүндэтгэн хамгаалах үүднээс өнөөгийн хөдөөгийн хүн амд үзүүлэх ЭМАШТ-ийн хүртээмж, чанарт илүүтэй анхаарч, сумын эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг

зохистой өөрчлөх замаар жинхэнэ утга агуулгаар нь “Сумын эрүүл мэндийн төв” болгож, хөгжүүлэх нь зүйтэй.

### **Ном зүй**

1. “Эрүүл мэндийн салбарын хөгжил” Хөтөлбөр (1998-2002). ЭМЯ, АХБ. УБ., 2003
2. Эрүүл Мэндийн Салбарын Мастер Төлөвлөгөө. УБ., 2005
3. Эрүүл мэндийн байгууллагын өөрчлөлт шинэчлэл. Эмхэтгэн, хянан тохиолдуулсан Н.Жаргалсайхан. ЭМЯ, АХБ, ЭМСХ-2 Төсөл. УБ., 2008
4. Health for All in the 21st Century. WHO, 1997
5. Millennium Development Goals-Based Comprehensive National Development Strategy of Mongolia. UB, 2008
6. Primary care in the driver's seat? Organizational reform in European primary care. The editors: Richard B. Saltman, Ana Rico, Wienke Boerma. Open University Press, McGraw Hill Education, 2006
7. Review of Experience of Family Medicine in Europe and Central Asia. Document of the World Bank. 2005
8. Rural Practice and Rural Health. WONCA, 1999
9. The Health Centre in District Health System. WHO, 1994
10. The World Health Report 2008: Primary Health Care Now More Than Ever. WHO, Geneva, 2008
11. WHO Regional Office for South-East Asia and WHO Regional Office for the Western Pacific. People at the centre of health care: harmonizing mind and body, people and systems. Geneva, WHO, 2007

Танилцаж, нийтлэх санал ёгсөн:  
Академич, анагаахын шинжлэх ухааны доктор,  
профессор Ц.Мухар